DURVUD-KHALKH-ENGLISH DICTIONARY

TSENDEE YUNGER

SOAS, UNIVERSITY OF LONDON
MONGOL BUSINESS INSTITUTE

DURVUD-KHALKH-ENGLISH DICTIONARY

TSENDEE YUNGER

Ulaanbaatar
Mongolia

2013
© Tsendee Yunger
Mongol Business Institute, Ulaanbaatar, Mongolia

PREFACE

This “Durvud-Khalkh-English dictionary” is the result of a language documentation project about the Durvud people who live in western Mongolia. The data for this project was elicited from 62 speakers from the bags Orlogo, Kholvoo, Khulst Nuur and Kharkhiraa in the communities Umnugovi, Ulgii, Ulaangom and Khovd of Uvs province. Most speakers were more than 60 years old, including my main informants D. Baast (76), S. Nokhoijav (63), J. Shavgants (82), B. Demverel (76), A. Pagmajav (61) and M. Togtokh (66).

The Durvuds are a nomadic people with a rich ethnic culture. Their dialect is the main dialect of the Oirat language in Mongolia and has preserved several features of the ancient Middle Mongolian language. However, due to the integration of the Durvud into a common Mongolian culture and society, the values and material characteristics of this local culture have lost a lot of ground in recent years. For instance; Durvud woman clothes and accessories, felt-made doors, hearths and ploughs have entirely fallen out of usage. Moreover, the Ikhel (a traditional Oirat musical instrument), tevsh (wooden plate), dombo (wooden pot), kiileg (shirt), and arkhad or khukhuur (large leather bags for perparing kumis) have become very rare. Parallel to the loss of the special vocabulary related to its culture, the overall vocabulary of the Durvud dialect is being assimilated to the Khalkha standard. Moreover, large numbers of rural Durvud are migrating to urban centers, exchanging their nomadic with a sedentary way of life. For these reasons, documenting the Durvud dialect had become crucial.

When compiling this Durvud-Khalkh-English dictionary, I made use of the audio, video and picture files, descriptions, translations, categorizations and explanations from the language documentation project. In addition, “The root words of the Durvud dialect” (Tsendee 2001) and “A grammar of the Oirat dialect” (Tsendee 2012) were used as well. The dictionary consists of the following sections: 1. Dwelling 2. Household and work equipment 3. Clothing 4. Sewing and ornaments 5. Accessories 6. Drink and Foods 7. Music 8.Livestock 9. Nature and environment 10. Grammer.

The Durvud words in the dictionary have been written with a special transcription and are accompanied by Khalkh explanations and English translations. Word category and word class have been indicated, and in some cases the morphological structure of words is shown as well. At the end, an alphabetical Durvud word index has been attached.

I believe that my documentation of the Durvud dialect, by providing information and materials on the Durvud dialect and Durvud ethnic and nomadic culture to scientists all over the world, can become an important tool for research into the Oirat language and its dialects.

I am very grateful to the School of Oriental and African Studies (SOAS) at the University of London for supporting my project with a Small Grant under the Endangered Language Documentation Program (ELDP) of the Hans Rausing Endangered Language Fund, and to their Endangered Languages Archive (ELAR) for archiving my materials. I also want to thank Benjamin Brosig, a doctoral student at Stockholm University, for providing me with methodological advice that significantly contributed to the successful completion of my project.

Tsendee Yunger
Mongol Business Institute
Ulaanbaatar, Mongolia
2013

ӨМНӨХ ҮГ

“Дөрвөд-Халх-Англи хэлний толь бичиг”- нь Монгол улсын баруун аймагт оршин суугаа дөрвөдүүдийн хэл яриаг баримтжуулсан судалгааны үр дүн юм. Судалгаанд Увс аймгийн Өмнөговь, Өлгий, Улаангом, Ховд сумын Орлого, Холбоо, Хулст нуур, Хархираа багийн 62 ярилцагч оролцсон, нийгмийн хэлний гол яригчид нь 60-өөс дээш настай, дөрвөд яригч Д.Бааст (нас76), С.Нохойжав(нас 63), Ж.Шавганц (нас 82), Б.Дэмбэрэл(нас76), А.Пагмажав (нас 61), М.Тогтох (нас 66) нар гол төлөөлөгч юм.

Дөрвөдүүд нүүдлийн ба угсаатны соёлын өвөрмөц онцлогтой. Дөрвөд аялгуу нь ойрад хэлний гол аялгуу бөгөөд эртний ба дунд үеийн монгол хэл, худам бичиг (монголчуудын үндэсний бичиг) - ийн онцлогийг өдгөө хүртэл хадгалж ирсэн байна. Гэвч нийгмийн харилцааны шаардлагаас үүдэн сүүлийн үед угсаатны соёлын үнэт зүйлс ховордон устаж байна. Тухайлбал: дөрвөд авгайн хувцас, гоёлын зүйлс, эсгий үүд, тулга, анжис зэрэг нь бүрмөсөн устаж, икэл (ойрадын үндэсний хөгжим), тэвш (модон таваг), домбо (модон сав), кийлэг (цамц), архад, хөхүүр (цагаан идээ хийх ширэн сав) зэрэг нь маш ховордсон байна. Түүнтэй холбоотой үг хэллэг мартагдан гээгдэхийн зэрэгцээ, дөрвөд аялгуу нь бусад (халх) аялгуунд уусан саармагшиж байна. Тэрчлэн дөрвөдүүд нүүдлийн ахуй, амьдралаас суурин амьдралд шилжих болсон байна. Иймээс дөрвөд аялгууг баримтжуулах судалгаа чухал ач холбогдолтой байлаа.

“Дөрвөд - Халх - Англи хэлний толь бичиг”- ийг хийхдээ монголын ойрадын дөрвөд аялгууг баримтжуулсан аудио, видео бичлэгүүд, фото зургийн сан, тайлбар, орчуулга, задлан ялгал, тодорхойлолтод тулгуурласнаас гадна “Дөрвөд аялгууны язгуурлаг үгс” (Ю.Цэндээ, 2001), “Ойрад аялгууны хэл зүй” (Ю.Цэндээ, 2012) хэл шинжлэлийн судалгааны бүтээлийг голлон ашиглалаа. Энэ толь бичиг нь дараах бүтэцтэй: 1.Гэр орон сууц 2. Ахуйн ба ажлын багаж хэрэгсэл 3. Хувцас хунар 4. Оёдол ба хээ 5. Гоёл чимэг 6. Унд, хоол хүнс 7. Мал сүрэг 8. Дуу хуур 9. Дэлхий ертөнц 10. Хэлзүй.

Толь бичгийн үгсийг ойрад аялгууны галиг үсгээр толгойлон бичлээ.Үгийн тайлбарыг халх аялгуугаар, орчуулгыг англи хэлээр бичив. Түүнчлэн тухайн үгийн харьяалагдах төрөл, үгсийн аймгийг тодорхойлж, зарим үгсийг бүтцээр задаллаа. Эцэст нь үгсийн жагсаалтыг дөрвөд-англи хэлээр үйлдэн хавсаргав.

Дөрвөд аялгууны баримтжуулалт нь дөрвөдийн хэл аялгуу, угсаа, нүүдлийн соёлын мэдээлэл, баримт материалыг дэлхийн эрдэмтэн, судлаачдад хүргэх, түгээх, улмаар ойрад хэл, аялгууны судалгааг хөгжүүлэхэд судалгааны чухал хэрэглэгдэхүүн болно гэдэгт итгэлтэй байна.

Дөрвөд аялгууг баримтжуулах төслийг дэмжсэн Англи улсын Лондонгийн Их сургуулийн SOAS (The School of Oriental and African Studies), төслийг санхүүжүүлсэн Ханс Раусингийн ELDP (Endangered Languages Documentation Programme), баримтыг архивласан ELAR (Endangered Languages Archive)- т талархал илэрхийлье. Энэ төслийг амжилттай хэрэгжүүлэхэд аргазүйн зөвлөгөө өгч тусалсан Стокгольмын Их сургуулийн докторант Бенжамин Бросигт баярлалаа.

Ю.Цэндээ
Монгол Бизнес Дээд сургууль
Монгол улс
Улаанбаатар хот
2013 он

TRANSCRIPTION ORDER

a	ā	ä	ā̈	b	w	d	dž	dz-z	
e	ē	ɢ	g	x	k	i	ī	j	l
m	n	ŋ	o	ō	ö	ō̈	p	r	s
š	t	ts	tš	u	ū	ü	ṻ		

EXPLANATION OF TRANSCRIPTION

short vowel: a, ä, e, i, o, ö, u, ü

long vowel: ā, ā̈, ē, ī, ō, ō̈, ū, ṻ

reduced vowel: ă, ă̈, ĕ, ĭ, ŏ, ŭ, ŭ̈,

too reduced vowel: ʌ

diphtong: $\bar{a}^{\breve{i}}$, $\bar{o}^{\breve{i}}$, $\bar{u}^{\breve{i}}$, $\bar{\ddot{u}}^{\breve{i}}$

reduplicate vowel: ōă, ōĕ, ō̈ĕ, ŭ̈ā̈, iu

consonant: d, t, dz, dž, z, ts, tš, s, š, j, r, l, k, x, ɢ, g
m, n, ŋ, b, w, p

palatal: d^{i}, t^{i}, r^{i}, l^{i}, k^{i}, g^{i}, m^{i}, n^{i}, b^{i}, w^{i}

THE CYRILLIC-MONGOLIAN ALPHABET

А а	Б б	В в	Г г	Д д	Е е	Ё ё	Ж ж	З з
И и	й	К к	Л л	М м	Н н	О о	Ө ө	П п
Р р	С с	Т т	У у	Ү ү	Фф	Х х	Ц ц	Ч ч
Ш ш	Щ щ	ъ	ы	ь	Э э	Ю ю	Я я	

ABBREVIATION

N. noun

V. verb

ADJ. adjective

ADV. adverb

PRON. pronoun

NUM. numeral

resp. respect word

tabo. tabu word

arch. archaism

GARTŠĬg	ГАРЧИГ	CONTENTS
ömnĕx üg	Өмнөх үг	Preface.....**I-III**
I. gER ORĂN SŪTS	**ГЭР ОРОН СУУЦ**	**DWELLING……...1-9**
1.1 ger sūts	Гэр сууц	Dwelling.....1
1.2 gerīn ed xogšil	Гэрийн эд хогшил	Houshold Items.....7
1.3 ɢal ɢulŭmt	Гал голомт	Fire.....8
1.4 arɢ$_{\Lambda}$săn tülā̄	Аргал ба түлээ	Cow dung and fuel.....9
II. BAGDŽ KERĔgSĔL	**БАГАЖ ХЭРЭГСЭЛ**	**EQUIPMENT……...9-20**
2.1 ɢal tülk kerĕgsĕl	Гал түлэх хэрэгсэл	Fire and stove tools.....9
2.2 arɢăs tū̆k kerĕgsĕl	Аргал түүх хэрэгсэл	Gathering animal dung tools.....11
2.3 ɢal, xā̄snā̄ kerĕgsĕl	Гал тогооны хэрэгсэл	Kitchen equipments.....11
2.4 ɢujr kīk kerĕgsĕl	Гурил хийх хэрэгсэл	Grinding tools 14
2.5 tsaɢān idē kīk kerĕgsĕl	Цагаан идээ хийх хэрэгсэл	Dairy tools.....14
2.6 ärk^{i} nerx kerĕgsĕl	Архи нэрэх хэрэгсэл	Distilling tools.....15
2.7 ars eldĕx kerĕgsĕl	Арьс элдэх хэрэгсэл	Leather, skin and fur preparation, tanning and currying equipment ...15
2.8 malīn tonŏg kerĕgsĕl	Малын тоног, хэрэгсэл	Animal gear.....15
2.8.1 töld dzörū̆lsĕŋ kerĕgsĕl	Төлд зориулсан хэрэгсэл	Gear for young five stock animal.....15
2.8.2 mor^{i}nā̄ tonŏg kerĕgsĕl	Морины тоног хэрэгсэл	Horse gear.....16
2.8.3 temā̄nā̄ tonŏg kerĕgsĕl	Тэмээний тоног хэрэгсэл	Camel gear.....17
2.8.4 äŋg^{i} kerĕgsĕl	Бусад хэрэгсэл	Other equipment……..18
2.9 ujdlīn kerĕgsĕl	Оёход зориулсан хэрэгсэл	Sewing tools.....18
2.10 ajlīn baɢdž	Хөдөлмөрийн багаж	Work tools…….....19
2.11 xadlăn xadăx kerĕgsĕl	Хадлан хадах хэрэгсэл	Hay-field tools.....19
2.12 aŋgīn dzewsĕg	Ангийн зэвсэг хэрэгсэл	Hunting gear.....19
2.13 noxād dzörū̆lsĕŋ kerĕgsĕl	Нохойд зориулсан хэрэгсэл	Dog gear.....20
III. XUBTSĂN XUNR	**ХУВЦАС ХУНАР**	**CLOTHING.....20-25**
IV. UJDŬL, KĒ	**ОЁДОЛ БА ХЭЭ**	**SEWING AND ORNAMENT…25**
V. GOJA	**ГОЁЛ ЧИМЭГ**	**ACCESSORIES.....26-28**
5.1 erĕgtā̄ kümnā̄ ɢoja	Эрэгтэй хүний гоёлын зүйлс	Accessories for man.....26
5.2 emĕgtā̄ kümnā̄ ɢoja	Эмэгтэй хүний гоёлын зүйлс	Accessories for woman.....28
VI. UMDĂN, XŌL KŰNSĔN	**УНД, ХООЛ ХҮНС**	**DRINKS AND FOOD……28-36**
6.1 tsā̄	Цай	Tea.....28
6.2 maxăŋ xōl	Махан хоол	Meat dishes.....29
6.2.1 ɢadăr maxăn	Гадар мах	Covering meat.....29
6.2.2 dotăr maxăn	Дотор мах	Insides.....31
6.2.3 tolɢā šīr	Толгой, шийр	Head and shin.....33
6.2.4 künd$_{\Lambda}$tā̄ xōl	Зоог шүүс	Banquet.....34
6.2.5 bütū̄ xōl	Битүү хоол	Dumpling type food.....34
6.2.6 nō̄ts maxăn	Нөөшилсөн мах	Tinned meat.....35
6.3 ɢujrtā xōl	Гурилтай хоол	Noodle soup.....35

6.4 bōrtsăg	Боов боорцог	Cookies.....36
VII. MAL SŰRg	**МАЛ СУРЭГ**	**LIVESTOCK……..36-43**
7.1 tawn züsŭm mal	Таван хошуу мал	Five kinds of livestock.....36
7.2 malān üs nōsăn	Малын үс ноос	Wool.....39
7.3 malān bā̆r kebtĕr	Малын байр, хэвтэр	Pen.....40
7.4 malān im	Малын им	Earmark.....41
7.5malān tamɢ$_{ʌ}$	Малын тамга	Brand mark.....41
7.6 üsn, tsaɢān idā̆	Сүү, цагаан идээ	Dairy products.....42
7.7 malān ars$_{ʌ}$ šir	Малын арьс, шир	Skins and hides.....43
VIII DŪ XŪR	**ДУУ, ХӨГЖИМ**	**MUSIC……43-44**
8.1 dūn	Дуу	Songs.....43
8.2 kögdžim	Хөгжим	Music.....43
8.3 bī	Биелгээ	Dance.....44
8.4 tūli, tsol	Тууль ба цол	Epic and title.....44
IX. DELKĀ, ERTĔMTS	**ДЭЛХИЙ, ЕРТӨНЦ**	**NATURE AND ENVIRONMENT**
9.1 ǩümn	**Хүн**	**Person**……...44
9.1.1 urŭg sadăn	Ураг төрөл	Kinship.....44
9.1.2 kümnā̆ erk$_{ʌ}$tĕn	Хүний биеийн эрхтэн	Body organs.....46
9.2 bā̆ɢă̆l^{i}	**Байгаль**	**Nature**……...49
9.2.1 teŋgĕr, ɢadzăr	Тэнгэр ба газар	Sky and land.....49
9.2.2 usŭn	Ус	Water.....51
9.2.3 urɢ$_{ʌ}$măl	Ургамал	Plant.....51
9.2.3.1 modăn, öwsĕn	Мод ба өвс	Trees and Grass.....51
9.2.3.2 xadlăn, tarālĭn	Хадлан, тариалан	Hay-field and Crops.....53
9.2.4 ämʲtă̆s	Амьтад	Animals.....54
9.2.4.1 aŋ ba äŋgʲ ämʲtă̆s	Ан ба бусад амьтан	Hunting and other animals…….....54
9.2.4.2 šowūd	Шувууд	Birds.....55
9.2.4.3 šäwʲdž	Шавьж	Insects.....56
X. KEL DZŰI	**ХЭЛЗҮЙ**	**GRAMMAR……...57-78**
ū̆l üg	Үйл үг	Verb.....57
tölā̆nā̆ üg	Төлөөний үг	Pronouns.....70
asūlt$_{ʌ}$	Асуулт	Questions.....71
temdĕg nerĕn	Тэмдэг нэр	Adjective.....71
ū̆lt$_{ʌ}$ nerĕn	Үйлт нэр	Adverb.....74
tōnā nerĕn	Тооны нэр	Numeral.....76
KELKĀSĔN	**ХЭЛХЭЭС**	**INDEX 78-111**

I. gER ORĂN SŪTS - ГЭР ОРОН СУУЦ - DWELLING

1.1 ger sūts - Гэр сууц - Dwelling

ger *N. Khal.* гэр (Монголчуудын үндэсний эсгий сууц. Гэр нь нүүхэд зохицсон, ачих, буулгах, барихад хялбар, мод, эсгийгээр барина) *Eng.* dwelling (Mongolian traditional felt tent. Portable ger which are circular structures supported by wooden frames and covered in wool felt. It is very easy to assemble and disassemble) *SD: Dwelling*

dörwĕd ger *Khal.* дөрвөд гэр (Дөрвөд ястны гэр нь бусад ястны гэрээс ялгарах онцлогтой. Тэд ихэвчлэн 5-8 ханатай гэрт амьдардаг. Өрх нь нэг дан, гурвалжин эсгий байна) *Eng.* durvud dwelling (Durvud ethnic group's traditional dwelling. It differs from other ethnic group's habitat. They usually dwell in habitats with 5-8 walls. The upper cover of Durvud habitat is made of one layer of felt in triangular shaped) *SD: Dwelling*




deglā̃ *N. Khal.* овоохой (Унь, хана, хаалга, эсгий бүрээсээр барьсан тооногүй шовгор түр сууц. Нүүдлийн замд хонох, өнжих үедээ барьдаг. Дэглээг бас жовлаа, шовлаа **šowlā, džowlā** гэж нэрлэнэ) *Eng.* type of dwelling (tepee-like temporary dwelling with felt walls, a door and poles without a skylight. It is built during overnight travels. It is also called **džowlā** and **šowlā)** *SD: Dwelling*



küwkŭg *N. Morph:* **küwk-g** *Khal.* хүвхүг (Хана, хаалгаар барьсан тооно, уньгүй түр сууц. Ханыг дугуйлж эсгий туургаар ороогоод, дээгүүр нь дээврээр бүтээдэг) *Eng.* type of dwelling (Cylindrical shaped, temporary dwelling built by walls and a door with a roof above it. Skylight and poles are not included in it) *SD: Dwelling*



xatxūr ger *Khal.* хатгуур гэр (Тоононд унь хатган барьж, бүрээс нөмөргөсөн түр сууц. Хатгуур гэрт хана байхгүй) *Eng.* temporary dwelling (temporary dwelling in which poles are attached to skylight and covered with drape without any walls) *SD: Dwelling*



šūrăg *N. Khal.* урц, муу гэр *Eng.* hut *SD: Dwelling*

xabtšāxā *N. Morph:* **xabtš-āxā** *Khal.* мөргөцөг (Хоёр ханыг толгойгоор нь зөрүүлэн хавсарч бариад, дээгүүр нь бүрээсээр бүрхсэн оромж) *Eng.* type of shelter (Shelter made by two walls crossed over each other's upper ends covered with felt drape) *SD: Dwelling*



džodgăr *N. Morph:* **džod-găr** *Khal.* жодгор (Бөс даавуугаар дөрвөлжин, босоо хэлбэртэй хийсэн оромж. Бадарчин үүрч

явдаг, гэр дотор багтдаг) *Eng*. type of shelter (Vertical shelter made by cloth in a rectangular shape. Itinerant monk carries it with him. Smaller than ger) *SD: Dwelling*

mā̆x/n *N. Morph:* **mā̆x-n** *Khal.* майхан (Бөс даавуугаар хийсэн, модон тулгууртай, гурвалжин хэлбэртэй оромж. Майхныг тууварчид, хадланчид хэрэглэнэ. Наадмын үед бөхчүүд байрладаг) *Eng.* tent (Triangular shaped shelter made by cloth with wooden pillar. Normally used by traveling herders and haymakers. Wrestlers stay in tents during the traditional Naadam festival) *SD: Dwelling*



asăr *N. Khal.* асар *(*Бөс даавуугаар хийсэн, модон тулгууртай, дөрвөлжин ханатай оромж. Асрыг ихэвчлэн баяр, наадмын үед төв хэсэгт барина. Асрын өмнө бөхчүүд дэвж, хурдан морины цол дуудна) *Eng.* big tent (Rectangular shaped shelter made by cloth with wooden pillar. It is usually built in the central part of the area celebrating festival. Wrestlers perform dancing and the praise is sung for race horses in front of the tent) *SD: Dwelling*




šar ger *Khal.* шар гэр (Мод огтлон, үзүүрийг холбож, шарласан мөчир, өвсөөр хучиж хийсэн оромж. Ховд голын сав, Түргэн, Хархираан өндөр уулсаар нутаглагч дөрвөдүүд шар гэрийг барьдаг. Ихэвчлэн анчид хэрэглэнэ) *Eng.* yellow ger (Dwelling made by lashing sticks and fallen off branches together and draping with foliage. Yellow ger is built by Durvuds who live in Khovd river bank and the mountainous area in Turgen and Kharkhiraa. Usually hunters build it) *SD: Dwelling*

gerā̆m bürĕlg/n *N. Khal.* шинэ гэр тааруулах найр *Eng.* Feast for new felt tent *SD: Dwelling; Activity*

gerā̆m mod/n *N. Khal.* гэрийн мод (Гэрийг хана, унь, тооно, хаалгаар барьдаг. Эдгээрийг “гэрийн мод” гэнэ) *Eng.* wooden frames (Ger is assembled by walls, poles, skylight and door. Those are called frames) *SD: Dwelling; Wooden frames*



xarātš *N. Morph:* **xar-ātš** *Khal.* тооно (Унь, багана тогтоодог, агаар, нарны гэрэл орох цамхагтай, дээшээ бөмбөгөр модон цагираг хүрээ) *Eng.* skylight (Circular dome-shaped wooden rim that supported by poles and pillars. It also has ventilation slats which allow air and sunlight to enter.) *SD: Dwelling; Wooden frames*



- **kürā̆** *N. Khal.* хүрээ (тоонын гадна цагариг) *Eng.* outer rim (outer rim of skylight) *SD: Dwelling; Skylight part*
- **kürd**ᵥ *N. Khal.* хүрд (тоонын дотно цагариг) *Eng.* inner rim (inner rim of skylight) *SD: Dwelling; Skylight part*
- **gol** *N. Khal.* гол (тоонын төв буюу орой) *Eng.* central part (central part or crown central part) *SD: Dwelling; Skylight part*
- **tsamx**ᵥ**rā** *N. Morph:* **tsamx-rā** *Khal.* цамхаг (Тоонын цагирагийн дотно талаар тэлж хийсэн нарийн мод) *Eng.* stretcher (wooden sticks that stretches

inside the rim of skylight) *SD: Dwelling; Skylight part*

- **xurɢŭd** *N. Morph:* **xurɢŭn-d** *Khal.* тоонын хуруу (Тоонын хүрээг тоонын голтой холбосон гүдгэр нарийн моднууд. Тоонын том, багаас шалтгаалж хургадын тоо олон, цөөн байдаг) *Eng.* stick of skylight (Wooden sticks that connects skylight rim with it's crown. The number of the sticks depends on the size of skylight) *SD: Dwelling; Skylight part*
- **xarātšān nük/n** *Khal.* тоонын нүх (Унь өлгөхөд зориулж тоонын хүрээнд гаргасан нүх. Тооны том, багаас шалтгаалж, нүхийг гаргана. Тоонод 66-88 нүх байна) *Eng.* hole of skylight (Holes that are made to insert poles in it. There are 66-88 holes based on the size of the skylight) *SD: Dwelling; Skylight part*

toxā xarātš̆ *Khal.* (Бургас модыг матаж хийсэн тооно. Тоононы цамхрааг гурав гурваар матсан бургасаар хийнэ. Ийм тооно хөнгөн байх ба малчид хэрэглэнэ) *Eng*. type of skylight (Skylight made by crossing shrubs over. Shrubs are crossed by three-sticks. It is light-weighted and herders use it *SD: Dwelling; Skylight*



ɵ̄ld xarātš̆ *Khal.* Унийг тоононд салахгүйгээр бэхэлсэн, хоёр залгаастай тооно. Одоо бараг хэрэглэхгүй болсон. *Eng.* type of skylight (Double joint skylight with permanently attached poles. It is nearly extinct now) *SD: Dwelling; Skylight*

kürd˄tā̆ xarātš̆ *Khal.* хорол тооно (Тоонын гол нь хүрдтэй, түүнд тулсан хуруунуудтай байна. Хар модоор хийнэ. Ихэвчлэн төв суурингийн айлууд хэрэглэнэ) *Eng.* type of skylight (Crown of the skylight that is wheel shaped. It is made of larch. Usually town-families use it) *SD: Dwelling; Skylight*



baxn *N. Khal.* багана (Гэрийн тооныг дооройс нь тулдаг шулуун мод. Гэрт хоёр багана байна) *Eng.* pillar (Straight pillar that supports skylight from bottom. Ger has two pillars) *SD: Dwelling; Wooden frames*

ɵ̄ldžĕm baxn *Khal.* Баганын толгой нь хөндлөн байна. Өвөөлжин толгойтой баганаар тоонын хоёр талын хүрээг тулдаг *Eng.* type of pillar (Upper-end of the pillar is wider. It supports the skylight from sideway rims) *SD: Dwelling; Pillar*

atstā baxn *Khal.* ацтай багана (Баганын толгой нь ацтай байна. Үүнийг тоонын гол ба хүрээнд тулдаг. Ихэвчлэн салхи шуургатай үед тулна) *Eng.* type of pillar (Pillar that has forky upper-ends. The pillar support the skylight from inner and side rims. It is usually used when wind blows) *SD: Dwelling; Pillar*



tsax *N. Khal.* цах (Жижиг гэрт салхи, шуурга болох үед түр зуур цах тулдаг. Бас эмээл, хазаар мэтийг өлгөнө) *Eng.* hook (It is temporarily used for smaller ger during thunderstorms and winds. Saddle and bridle are hooked to it) *SD: Dwelling; Pillar*

ɵ̄d/n *N. Morph*: **ɵ̄d-n** *Khal.* хаалга *Eng.* door *SD: Dwelling part*

išk̄ā ɵ̄d/n *Khal.* эсгий үүд (Эсгийгээр хийсэн хаалга. Эсгий үүдийг эвхэж, тотго дээр

тавьдаг. Буулгасан байх үед зүүн талаас нь сөхөж гэрт ордог ёстой. Одоо хэрэглэхээ больсон) *Eng.* felt door (It is folded up to a door lintel. It should be opened from the left-side to enter into ger. It is no longer be used now) *SD: Dwelling part*

xāɢūl *N. Morph*: **xā-(ɢ)ūl** *Khal.* хаалга *Eng.* door *SD: Dwelling part*

mor^{i}ŋ xāɢūl *Khal.* давхар модон хаалга (одоо бараг хэрэглэдэггүй) *Eng.* double-layered wooden door (It is nearly no longer be used now) *SD: Dwelling*; *Wooden frames*

džašăŋ xāɢūl *Khal.* модон дан хаалга. *Eng.* wooden door *SD:Dwelling; Wooden frames*



- **tur** *N. Khal.* хаалганы яс мод. *Eng.* frame of door *SD: Dwelling*; *Door part*
- **erkĕn** *N. Morph*: **erk-n** *Khal.* тотго (Хаалганы дээд тал. *Eng.* door lintel *SD: Dwelling*; *Door part*
- **mörgū̆l** *tabo. N. Morph*: **mörg-ū̆l** *Khal.* тотго *Eng.* door lintel *SD: Dwelling*; *Door part*
- **alxăts** *N. Morph*: **alx-ts** *Khal.* босго (Хаалганы доод хөндлөн мод*) Eng.* threshold (The wooden piece placed beneath door) *SD: Dwelling*; *Door part*
- **baks$_{ʌ}$** *N. Khal.* хатавч *Eng.* jamb of a ger and the latticework *SD: Dwelling*; *Door part*
- **ōĕns/ō̆ns** *N. Khal.* оньс, түгжээ *(*Хаалганы дээд, доод талд модон түгжээ хийдэг) *Eng.* wooden locks (Wooden locks placed on upper and lower part of door) *SD: Dwelling*; *Door part*

un^{i}/n *N. Morph*: **un^{i}-n** *Khal.* унь (Тооныг зүг бүрээс хатган тогтоох урт урт моднууд. Унийн бөгсийг хананы толгой дээр тавьж, сэгэлдрэгээр бэхэлнэ) *Eng.* caber (poles or a ger which make up roof) *SD: Dwelling*; *Wooden frames*

- **dzet** *N. Khal.* унины үзүүр *Eng.* point of caber *SD: Dwelling*; *Wooden frames*
- **un^{i}nā̆ tšēdž** *Khal.* унины цээж *Eng.* head of caber *SD: Dwelling*; *Wooden frames*
- **un^{i}nā̆ böks$_{ʌ}$** *Khal.* унины бөгс *Eng.* tail of caber *SD: Dwelling*; *Wooden frames*

totxān un^{i}/n *Khal.* тотгоны унь (Хаалганы тотгонд таван унь өлгөнө. Тотгоны унь нь сэгэлдрэггүй байна) *Eng.* linder cabers (Five poles are attached to linder. Linder poles do not have loops) *SD: Dwelling*; *Wooden frames*

term$_{ʌ}$ *N. Khal.* хана (Бургас модыг тусгайлан засаж, хооронд нь үдсэн нарийн моднууд. Ханыг хоёр тийш сунгаж босгох ба эвхэж болно) *Eng.* wall (Stapled sticks that are made by carefully carved shrubs) *SD: Dwelling*; *Wooden frames*



- **~ā̆n tolɢā** *Khal.* ханын толгой (Унины бөгсийг тавьж бэхлэх жижиг ацнууд) *Eng.* upper-ends of wall (Upper ends of wall that supports poles) *SD: Dwelling part; Wall part*
- **~ā̆n šīr** *Khal.* ханын шийр *(*Ханын доод талын солбин зөрсөн ац) *Eng:* lower-end of wall (lower-end of wall which is fork headed) *SD: Dwelling part; Wall part*
- **~ā̆n üdā̆r** *Khal.* ханын үдээр *(*Ханыг товчлон үдэх бэхлээс. Үүнийг тэмээний ширээр хийдэг) *Eng.* staple to connect walls (Staples are made from camel skin) *SD: Dwelling part; Wall part*

- **~a̲n ba̲r** *Khal.* ханын нүд (Дэлгэсэн ханын дөрвөлжин нүд) *Eng.* space of wall (Rectangular shaped open spaces of stretched wall) *SD: Dwelling part; Wall part*
- **~a̲n bōlgā** *Khal.* ханын боолт (Ханыг хооронд нь залган бэхлэх нарийн оосор) *Eng.* wall-tie (String that ties walls together) *SD: Dwelling part; Wall part*
- **~a̲n am/n** *Khal.* ханын хоёр хажуу *Eng.* two-sides of wall *SD: Dwelling part; Wall part*
- **nū̲ts** *N. Morph*: **nū̲-ts** *Khal.* ханын нүдний зайнаас хамаарах хэмжээ *Eng.* size of the spaces of wall *SD: Dwelling part; Wall*
- **ers$_{\Lambda}$** *N. Khal.* ханын өндөр *Eng.* size or high of wall *SD: Dwelling part; Wall*

barūm baksān term$_{\Lambda}$ *Khal.* баруун хатавчны хана *Eng.* wall that is connected to right side of door *SD: Dwelling part*

dzū̲m baksān term$_{\Lambda}$ *Khal.* зүүн хатавчны хана *Eng.* wall that is connected to left side of door *SD: Dwelling part*

iškā̲ *N. Khal.* эсгий *Eng.* felt *SD: Dwelling; Cover*

iškā̲ bürā̲s/n *Khal.* эсгий бүрээс (Эсгийгээр хийсэн дээвэр, туургыг эсгий бүрээс гэнэ) *Eng.* felt cover (Roofs and side covers made by felt) *SD: Dwelling; Cover*

dēwĕr *N. Morph*: **dē-wĕr** *Khal.* дээвэр (Гэрийн унины дээгүүр бүтээсэн хагас тойрог эсгий бүрээс. Гэрт хойт ба урд дээвэр бий. Дээврийн хоолой, хоёр хажуу, хормойг зээгээр хөвөөлж оёно) *Eng.* felt roof (Half circular felt cover for cabers. There are back and front roofs in ger. Neck, two-sides and bottom part are sewn on edges) *SD: Dwelling; Cover*



dzā̲ntsū̲r *N. Morph*: **dzā̲-(n)-tsū̲r** *Khal.* зайчуур (гэрийн хоёр дээврийн зөрүүлсэн зай) *Eng.* space left between two roofs *SD: Dwelling; Cover*

tūrg *N. Khal.* туурга (Гэрийн ханыг гадна талаар нь нөмөргөж бүтээх эсгий. Гэр ихэвчлэн 4-6 туургатай байдаг. Туурганы хоолой, хоёр хажууг зээглэнэ. Туурганы хоёр өнцөгт оосор бэхэлнэ) *Eng.* felt cover (Pieces of felt covering frame of a ger and forming its walls. Ger usually has 4-6 pieces of felt frame. Neck and two sides of frame is sewn together. Straps are attached to two-edges of frame) *SD: Dwelling; Cover*



örk$_{\Lambda}$ *N. Morph*: **ör-k** *Khal.* өрх (Гэрийн тоонын хойт хэсгийн дээгүүр бүтээх гурвалжин эсгий. Өрхний захыг зээглэсэн байх ба гурван талдаа оосортой байна) *Eng.* felt cover for skylight (Triangle felt cover of backside of skylight of the ger. Sides of felt cover are sewn and with straps on three sides) *SD: Dwelling; Cover*

xālt$_{\Lambda}$ *N. Morph*: **xā-lt** *Khal.* хаалт (Тоонын урд хэсгийн дээгүүр бүтээх гурвалжин эсгий ба бөс. Өвлийн хаалтыг эсгийгээр, зуны хаалтыг бөсөөр хийдэг) *Eng.* cover (Triangle felt or cloth that covers front side of skylight) *SD: Dwelling; Cover*

irg$_{\Lambda}$ *N. Khal.* гэрийн хаяа *Eng.* the skirt of felt tent *SD: Dwelling; Cover*

irgĕbtš$_{\Lambda}$ *N. Morph*: **irgĕ-btš** *Khal.* хаяавч (Гэрийн хаяагаар тойруулан орооход зориулан ширж оёсон эсгий) *Eng.* stitched felt that covers lower edge of ger *SD: Dwelling; Cover*

gadăr bürā̲s/n *Khal.* гадна бүрээс (Дээвэр ба туурганы гадуур нөмөргөсөн даавуу

давхарлага. Дээр үеийн гэрт гадуур бүрээс байгаагүй) *Eng.* outer cover (Cotton layer that covers roof and walls. In earlier times, there were no outer cover) *SD: Dwelling; Cover*

tsawăg *N. Khal.* цаваг (Гэрийн дээврийн доор унин дээр нөмөргөсөн туургагүй даавуун бүрээс. Бас дотуур бүрээс, дотуур цаваг гэж нэрлэдэг. Ихэвчлэн цагаан даавуугаар хийнэ. Дээр үеийн гэрт цаваг байгаагүй) *Eng.* cotton cover between roof and cabers (It is also called inner cover. Usually made by white cotton. In earlier times, there were no inner cover) *SD: Dwelling; Cover*

dzawăg *N. Khal.* заваг (Туурга, цаваг хоёрын хоорондын завсар зай) *Eng.* Space between felt cover and inner cover *SD: Dwelling; Cover*

köšĭg *N. Khal.* гэрийн хөшиг (Гэрийн ханын дотно талд халхалж татсан даавуун эд. Нүүдлийн гэрт хөшиг байдаггүй. Хөшгийг сүүлийн үеэс хэрэглэх болсон) *Eng.* curtains covering the walls of a ger (Cotton piece used to cover inner part of wall. Nomadic ger does not have curtain. Curtain has been used in modern times) *SD: Dwelling part*

ōsăr *N. Khal.* оосор (Гэрийн дээвэр, туурга, өрх, бүрээс, цаваг зэргийг бэхлэн тогтоох зориулалттай, малын хялгас, ноосоор томж хийсэн урт уяа) *Eng.* strap (Long, braided string made of animal hair and wools that ties roof, cover of wall, cover of skylight, outer layer and inner layer etc) *SD: Dwelling; Strap*

bitš *N. Khal.* бүч (Оосрыг тогтоох гогцоо. Гэрт 24 оосор, бүч байдаг) *Eng.* knot of rope used to tie straps (Ger has 24 straps and knots) *SD: Dwelling; Strap*

dzēg *N. Khal.* зээг (Эсгий дээвэр, туурга, өрх, ширдэг зэргийн захыг сунахаас хамгаалж, хөвөөгөөр нь тойруулан оёсон, нарийн хос оосор. Зээгийг ихэвчлэн хар ноосоор хийнэ. Зээгийг үзэмжтэй харагдуулахын тулд зөв ба буруу эрчтэй томж зэрэгцүүлэн оёдог) *Eng.* edging strap (Double thin straps that are sewn around the edges of felt roof, cover of wall, cover of skylight and rug to prevent from stretching out. It is usually made by black wool. Straps are braided clockwise and anticlockwise to make it look neat) *SD: Dwelling; Strap*

büs *N. Khal.* бүслүүр (гэрийг тойруулан бэхэлсэн хялгасан татлага) *Eng.* woolen cord (woolen cord for encircling a ger) *SD: Dwelling; Strap*

ɢadăr büs *Khal.* гадуур бүслүүр (Гэрийн гадна талаар татсан бүслүүр. Жижиг гэр хоёр бүстэй, том гэр гурван бүстэй байдаг. Үүнийг дээд, дунд, доод бүс гэж нэрлэдэг) *Eng.* outer cords encircles ger (Small ger has two cords whereas big ger has three cords that are called upper, middle and lower cords) *SD: Dwelling; Strap*

dotăr büs *Khal.* дотуур бүслүүр (Гэрийн хана болон гэрийн модыг унахаас хамгаалж татсан бүс. Дотуур бүс нь 1-2 байна) *Eng.* inner cords (Cords prevent walls and other wooden structures from falling down. There are 1-2 inner cords in ger) *SD: Dwelling; Strap*

xošlăn *N. Morph*: **xoš-lăn** *Khal.* хошлон (Сарлагийн хялгасаар томж, тагнаа гарган нийлүүлж оёсон гэрийн бүслүүр) *Eng.* cord (Cord made from braided ox hair) *SD: Dwelling; Strap*

ergā̆ *N. Morph*: **erg-ā̆** *Khal.* тооныг тогтоох, эргүүлж тэгшлэхэд зориулсан уяа (Тооно 2 ба 4 эргээтэй) *Eng.* cord of skylight of the ger to make it stay stable (Skylight has 2 or 4 cords) *SD: Dwelling; Strap*

saldărɢ *N. Khal.* сэгэлдрэг (Унийг хананд өлгөж тогтооход зориулан хялгасаар томж хийсэн гогцоо оосор) *Eng.* knot (Hoop strap to connect poles to wall. It is made by braided animal hair) *SD: Dwelling; Strap*

dobtălɢ *N. Morph*: **dobt-lɢ** *Khal.* даруулга (Гэрийн урд дээврийн дээгүүр хойт дээврийг даруулан уясан хоёроос гурван хос татлага) *Eng.* strap (2-3 pairs of ropes to fasten the backside of roof over front side of roof) *SD: Dwelling; Strap*

tšiktăx *N. Morph*: **tšikt-x** *Khal.* чагтага (Гэрийн тоононы голоос уях оосор. Салхи, шуурга болох үед чагтгаас хүнд юм дүүжлэн доош даруулдаг) *Eng.* strap (Strap attached to the central part of skylight. Heavy weight is placed to the bottom-end during thunderstorm) *SD: Dwelling; Strap*

nabtsʌ/naptsʌ *N. Khal.* навтас (Нооронхой муу эсгий, хөдөс. Дэвсэж хэрэглэнэ) *Eng.* felt (Ragged felt and rug. Placed on floor) *SD: Dwelling; Mat*

tŏ̄rŭ̄l *N. Morph*: **tŏ̄r-ŭ̄l** *Khal.* тойруулга (Гэрт дэвсдэг хагас тойрог эсгий дэвсгэр) *Eng.* circular mat (Half circular felt mat for ger) *SD: Dwelling; Mat*

ɢuj dewsʌkĕr *Khal.* тал дэвсгэр (Гэрийн хоёр хажуугаар дэвсэнэ) *Eng.* half mat (Placed on both sides on floor of ger) *SD: Dwelling; Mat*

širdĭg *N. Morph*: **šir-dĭg** *Khal.* ширдэг (Дэвсэхэд зориулсан ширмэл эсгий) *Eng.* stitched felt mat *SD: Dwelling; Mat*

šal *N. Khal.* шал (Шал нь дугуй хэлбэртэй, 10-12 хэсэгтэй байна. Хот, суурингийн айлууд модон шалтай байдаг. Хөдөөний айлд шал байдаггүй) *Eng.* wooden floor (It is circular and composed of 10-12 parts. Countryside families do not own floor) *SD: Dwelling; Mat*

1.2 gerīn ed xogšil - Гэрийн эд хогшил – Household Items

ed xokšĭl *Khal.* эд хогшил (Гэрийн эд хогшил нь нүүхэд зохицсон, ачиж, буулгахад хөнгөн байдаг. Мод, эсгий, малын арьс ширээр хийсэн эд зүйл зонхилно) *Eng.* furniture (Furniture for ger is made to be transported effortlessly and it is light-weighted. Items are usually made of wood, felt and rawhide) *SD*: *Household*

atsā xoš *Khal.* ачаа *Eng.* load *SD: Household*

abdăr *N. Khal.* авдар (Эд, хөрөнгөө хадгалах модон хайрцаг. Тэмээнд ачихад зориулж хоёр талд нь оосор хийдэг) *Eng.* chest/locker (Wooden box to keep valuable items. To load between camel humps, two straps are attached on the two sides of it) *SD*: *Household*



tsŏ̄dž *N. Khal.* цоож *Eng.* lock *SD: Household*

- **āg** *N. Khal.* цоожны өргөс *Eng.* tongue *SD: Household; Lock part*
- **tülkŭ̄r** *N. Khal.* түлхүүр *Eng.* key *SD: Household; Lock part*

ɢalīn ör *Khal.* аяганы шүүгээ (Дээр нь аяга, таваг тавьдаг, 4 хөлтэй модон ширээ) *Eng.* table (4 legged, wooden table for dishes) *SD*: *Household*

ükŭ̆g *N. Khal.* хөлийн авдар (Гал тогооны шүүгээ) *Eng.* chest for kitchen *SD*: *Household*



- **ükgīn ges/n** *Khal.* үхгийн дотор зай *Eng.* chest of drawer's inside space *SD*: *Household; Drawer*
- **ükgīn nüd/n** *Khal.* татуурга *Eng.* drawer(s) of a chest *SD*: *Household; Drawer*

täw^{i}ts$_{ʌ}$ *N. Morph*: **täw^{i}-ts** *Khal.* эргэнэг *Eng.* kitchen stand *SD*: *Household*

xörūl *N. Khal.* эргэнэг (Гал тогооны эдлэл хэрэглэлийг тавьдаг, 4 хөлтэй модон тавиур) *Eng.* kitchen stand (4-legged, wooden stand for kitchen utensils) *SD*: *Household*



or *N. Khal.* ор *Eng.* bed *SD*: *Household*

modn or *Khal.* модон ор (Хүн унтахад зориулсан модон эдлэл) *Eng.* wooden bed (Piece of a wooden furniture used as a place to sleep) *SD*: *Household; Bedding*

tūw *N. Khal.* арьсан битүү хөнжил *Eng.* sheepskin blanket *SD: Bedding*

džintŭ *N. Khal.* дэр *Eng.* pillow *SD: Household; Bedding*

tüntŭg *N. Morph*: **tünt-g** *Khal.* дэр (Хоёр талдаа дугираг ба дөрвөлжин оруулгатай дэр) *Eng.* pillow (Round or square sided pillow) *SD: Household; Bedding*

1.3 ɢal ɢulŭmt - Гал голомт - Fire

ɢal *N. Khal.* гал (Галыг тулга ба зууханд түлнэ. Аргал ба модоор гал түлнэ. Дөрвөдүүд галыг дээш мандан бадрахын бэлэг тэмдэг гэж дээдэлдэг) *Eng.* fire (Fire is burned in fireplace and stove. It burns cow dung and wood. Fire is a symbolism of upward success for Durvuds) *SD: Fire*

tsog *N. Khal.* цог (Цогийг унтраахгүйгээр манаж хоноод гал асаадаг. Аргалын галын цог дээр арц уугиулж сан тавьдаг. Улаан цог дээр давс цацаж, их үнэр, дуу гаргаж хүүхдийг, ариусгана) *Eng.* ember (Ember is fed overnight to burn fire next day. Cedar is burnt on dung ember to purify. To purify a child, salt is spread on the red ember making a loud noise and odor) *SD: Fire*

dzäl^{i} *N. Khal.* дөл (Галын дөл дээр согож, мах шардаг) *Eng.* flame (Meat is roasted over flame) *SD: Fire*

üms/n *N. Morph*: **üm(~n)s-n** *Khal.* үнс (Аргалын үнс хүүхдийн шээсийг сайн шингээдэг тул живх хийдэг. Аргалын үнсийг талбайд цацаж, ургамлын хортон шавжийг устгана) *Eng.* ash (Dung ash is used as a baby diaper, because of its high adsorption quality. Dung ash is splattered on the ground to kill pests) *SD: Fire*

tšindĕr *N. Khal.* чандруу *Eng.* ashes *SD: Fire*

urm$_{ʌ}$ *N. Khal.* нурам (Галын нурам дотор унь, хананы махир модыг хийж, хучаад тэгш болгодог) *Eng.* hot ashes (Bent poles and wall sticks are placed on hot ashes to make it flat) *SD: Fire*

utā/n *N. Morph*: **utā-n** *Khal.* утаа (Аргалын утаа баагиулж, ялаа, шумуулыг хөөнө. Шинэ махыг гадна талаас нь утаж, өтөхөөс хамгаална. Арьс, ширийг утаж, эдэлгээг сайжруулна. Өвлийн улиралд малын хот, саравчинд утаа тавьж, хүйтний жинг багасгадаг) *Eng.* smoke (Dung smoke is used as a fly and mosquito repellent. Fresh meat is smoked to prevent from spoiling. Rawhide and skin is smoked to lengthen the durability. During the winter, court yard and shed are smoked to keep the air less cold) *SD: Fire*

kō *N. Khal.* хөө (Яс хугарсан үед хөөг уухад түргэн эдгэдэг гэж үздэг. Шөнийн цагт нялх хүүхдийг гадаа авч явахдаа чөтгөрөөс хамгаалдаг гэж үзэн хамарт нь хөө түрхэж домнодог) *Eng.* black ash (It heals the bone fracture fast if it’s drunk. At night, when the baby is taken outside, applying black ash on baby’s nose protects from demons) *SD: Fire*

1.4 arɢʌsăn tülā̆ - Аргал ба түлээ - Cow dung and fuel

arɢăs/n *N. Morph*: **arɢăs-n** *Khal.* аргал *Eng.* dried cow dung *SD: Fuel*

bambā *N. Morph*: **bamb-ā** *Khal.* овоож давхарлан хатсан том аргал (Удаан асах бөгөөд илч сайтай) *Eng.* big, thick dry cow-dung (Burns for extended time and high quality) *SD: Fuel type*

sär^{i}mā̆ *N. Morph*: **sär^{i}-mā̆** *Khal.* саримдаг *Eng.* thin cow-dung *SD: Fuel type*

sär^{i}mdă̆g *N. Morph*: **sar^{i}-m-dă̆g** *Khal.* нимгэн сарсгар аргал (Түргэн асна) *Eng.* thin cow-dung (It ignites rapidly) *SD: Fuel type*

kok arɢăs/n *Khal.* хөх аргал (Хатаад хөхөрсөн аргал бөгөөд илч сайтай байна) *Eng.* blue dung (Over dried cow-dung with high quality) *SD: Fuel type*

xorɢăs/n *N. Morph*: **xorɢăs-n** *Khal.* хоргол *Eng.* droppings of sheep, goat and camel *SD: Fuel type*

keltĕrkā̆ *N. Morph*: **kelt-rkā̆** *Khal.* хомоол *Eng.* horse-dung *SD: Fuel type*

körl$_{ʌ}$ *N. Morph*: **kör-l** *Khal.* хөрзөн (Хатаж дагтаршсан хонь, ямааны ялгадас) *Eng.* (hardened dung and urine of sheep and goats *SD: Fuel type*



šar bās/n *Khal.* (Адууны нойтон баас) *Eng.* dump dung of horse *SD: Fuel type*

bāgūl *N. Morph*: **bāg-ūl** *Khal.* (Адууны нойтон баас, хомоол) *Eng.* type of dung (dump dung of horse) *SD: Fuel type*

dardz$_{ʌ}$ *N. Morph*: **dar-dz** *Khal.* (Модны унасан, хуурай мөчрөөр бэлдсэн түлээ) *Eng.* type of firewood (firewood prepared from dry branches of tree) *SD: Fuel type*

II. BAGDŽ KERĔgSĔL - БАГАЖ ХЭРЭГСЭЛ - EQUIPMENT

2.1 ɢal tülk kerĕgsĕl - Гал түлэх хэрэгсэл - Fire and stove tools

tšolūn tulɢ *Khal.* чулуун тулга (Гал түлэхэд зориулж, гурвалжлан тавьсан хээрийн гурван чулуу. Ил гал түлэх ба дээр нь тогоо тавьж цай, хоол хийнэ. Ихэвчлэн аян замын хүмүүс, анчид чулуун тулгыг тулдаг. Явахдаа түлсэн галаа унтрааж, тулганы нэг чулууг хөнддөг ёстой) *Eng.* rock brazier (Three piece of rocks placed in triangular spot to make fire. Pot is placed on the open fire to make tea and cook. Usually, travelers and hunters use rock fireplace. When they leave, they damp the fire and move one of the rocks) *SD: Fireplace type*

tömĕr tulɢ *Khal.* төмөр тулга (Ил задгай гал түлж, дээр нь тогоо тавих төмөр хэрэгсэл. Тулга нь голдуу 3-4 хөлтэй байна. Одоо тулгыг гэрт тулдаггүй. Тулга нь дараах хэсгээс бүтнэ) *Eng.* metal brazier (Metal brazier to burnopen fire and cook in a pot. Stove usually has 3-4 legs. Stove is not used in home now. Stove is comprised of following parts) *SD: Fireplace type*

- **köl** *N. Khal.* хөл (Тулгыг тулсан босоо төмөр) *Eng.* leg (Metal leg to support brazier) *SD: Fireplace part*
- **šörg** *N. Khal.* шөрөг (Тулганы хөлийн дээр тогоо тавихаар тогтоосон этгэр төмөр) *Eng.* pointed stick (Metal piece attached to its legs that holds pot) *SD: Fireplace part*

- **büs** *N. Khal.* бүс *(*Тулгыг тойруулж бэхэлсэн төмөр бүс) *Eng.* wrap (Encircling metal wrap that makes of brazier) *SD: Fireplace part*

xūwăn/xōwăn *N. Khal.* зуух (Дотор нь гал түлэхэд зориулж төмрөөр хийсэн бортогон хэлбэртэй хэрэгсэл) *Eng.* stove (Cylindrical shaped metal piece to burn fire inside) *SD: Fireplace type*



- **~gīn bo̅r** *Khal.* зуухны хажуу тал *Eng.* jambs of stove *SD: Fireplace; Stove part*
- **~gīn ges/n** *Khal.* зуухны ходоод *Eng.* space inside stove *SD: Fireplace; Stove part*
- **~gīn am/n** *Khal.* зуухны ам (Зуухны өмнө талын талд байгаа гал сорох нүхтэй хаалга) *Eng.* stoke hole door *SD: Fireplace; Stove part*
- **baxū** *N. Morph*: **bax-ū** *Khal.* хүхээ (Зуухны утаа гарах нүх) *Eng.* stovepipe (Hole that emits smoke from stove) *SD: Fireplace; Stove part*
- **tag** *N. Khal.* зуухны таглаа (Зуухны дээд талын бариултай хавхаг) *Eng.* stove lid with handle *SD: Fireplace; Stove part*
- **širā̆** *N. Khal.* зуухны ширээ (Зуух нь ширээтэй ба ширээгүй хоёр янз байна. Зуухны ёроолд хийсэн давхарлагыг ширээ гэнэ. Зуухны доорх газар ба шал халахаас хамгаалж, зуухыг ширээтэй хийдэг. Зарим зуухны ширээнд үнсний татуурга байдаг) *Eng.*floor for stove (Floor protection pad inserted between floor and stove. Some does not have it. Some pads have ash holder) *SD: Fireplace; Stove part*

jendĕn *N. Khal.* яндан (Зуухны утааг дээш сорж гаргах төмөр хоолой) *Eng.* chimney (A stovepipe is the pipe which conducts smoke from stove to its chimney) *SD: Fireplace; Stove part*

- **jendĕŋgīn tšimĭg/n** *Khal.* яндангийн чөмөг (Янданг 2-4 төмөр хоолой залгаж хийнэ) *Eng.* stovepipe (2-4 pipes are conjoined to make stovepipe) *SD: Fireplace; Chimney part*

tsorgʌ *N. Khal.* яндан *Eng.* chimney *SD: Fireplace; Stove part*

šaxăltʌ *N. Morph*: **šax-lt** *Khal.* сойлт (Зуухны галын соролтыг тохируулах янданд угласан төмөр шахуурга) *Eng.* smoke pump (Metal smoke pump installed to chimney) *SD: Fireplace; Stove part*

tšimkŭ̅r *N. Morph*: **tšimk-ŭ̅r** *Khal.* галын хайч (Аргал, түлшийг барьж чимхэн зууханд хийх хэрэгсэл) *Eng.* fire tongs (Tongs are used for picking up pieces of cow dung and firewood and placing them on a fire) *SD: Fireplace tool*



šilă̅gŭ̅r *N. Morph*: **šilă̅-(g)ŭ̅r** *Khal.* шилээвэр (Тулганы галыг хутгах, сэргээх хэрэгсэл. Одоо дархан хүмүүс хэрэглэдэг) *Eng.* poker (It is any metal instrument for tending a fire. Now blacksmiths use it) *SD: Fireplace tool*

keldŭ̅r *N. Morph*: **kel-dŭ̅r** *Khal.* үнсний ухуур *Eng.* stove ashtray *SD: Fireplace tool*

arɢăsnā xundzʌ *N. Khal.* дөрвөлж (Аргал, түлш хийдэг хайрцаг) *Eng.* firewood and cow dung box *SD: Fireplace tool*

šumăr *N. Khal.* өөхөн дэн (Малын өөхийг хайлж, гол хийгээд шумар асаадаг. Шумрын голыг томсон хөвөнгөөр

хийнэ. Бас шумрын өөхөнд хонины 2-5 ширхэг хоргол хийж гэрэл гаргаж болно) *Eng.* fat lamp (Cattle fat is melt and absorbed to cotton tinder. Also, 2-5sheep droppings could be inserted in a tinder to ignite light) *SD: Fire; Light type*

šiděndzʌ *N. Khal.* чүдэнз *Eng.* match *SD: Fire*

dzurūl *N. Morph:* **dzur-ūl** *Khal.* шүдэнз *Eng.* match *SD: Fire*

2.2 arɢăs tū̆k kerĕgsĕl - Аргал түүх хэрэгсэл - Gathering animal dung tools

arăg *N. Khal.* араг (Аргал түүхэд зориулсан модон сагс. Арагт бас ачаа тээш хийнэ. Бургасыг матаж, үдээрээр үдэж араг хийнэ) *Eng.* wooden basket used for picking up cow-dung (It is also used as carriage. It is made of stapled brushwoods) *SD: Container; Basket type*



šēdzgā̆ *N. Khal.* шээзгий *Eng.* smaller wooden basket *SD: Container; Basket type*

sawŭr *N. Khal.* савар (Аргал, түлш мэтийг түүх, цуглуулах ац салаатай модон хэрэгсэл. Сүүлийн үед саврын этэх хэсгийг төмрөөр хийдэг болсон) *Eng.*Wooden fork for collecting cow-dung (Now, the end of the fork is made by metal) *SD: Basket part*

2.3 ɢal, xā̆snā̆ kerĕgsĕl - Гал тогооны хэрэгсэл - Kitchen equipments

xā̆s/n *N. Morph*: **xā̆s-n** *Khal.* тогоо (Цай, хоол болгох дэрэвгэр амтай сав) *Eng.* pot (Round container to cook) *SD: Kitchen*

tsō̆ xā̆s/n *Khal.* ширмэн тогоо (Амсар нь дэрэвгэр, 2-4 бариултай, ширмээр хийсэн тогоо) *Eng.* cast-iron pot (with 2-4 handles and wide) *SD: Kitchen; Pot type*

tuŋxū *N. Khal.* данх *Eng.* kettle *SD: Kitchen*

dombʌ *N. Khal.* домбо (Шингэн зүйл агуулах мод, гуулиар хийсэн сав) *Eng.* jug (Vessel for liquids made by wood or brass) *SD: Kitchen; Kettle*

tšū̆gĕn *tabo. Morph*: **tšū̆g-n** *N. Khal.* данх *Eng.* kettle *SD: Kitchen; Kettle*

dū̆džĭn *N. Morph*: **dū̆dž-n** *Khal.* төмөр хувин *Eng.* metal bucket *SD: Kitchen; Container*

sūlgʌ *N. Khal.* суулга, хувин *Eng.* pail, bucket *SD: Kitchen; Container*

modn sūlgʌ *Khal.* модон хувин (2-3 төмөр бүслүүртэй модон сав. Үүнд малын сүү, цагаан идээ хийнэ) *Eng.* wooden bucket (Wooden bucket with 2-3 pieces of hoop iron. Milk and milk products are stored in it) *SD: Kitchen; Container*



küw *N. Khal.* торх (Модоор хийсэн том сав. Ихэвчлэн айраг хийнэ) *Eng.* big wooden barrel (Usually fermented mare's milk is stored in it) *SD: Kitchen; Container*

tuŋ/tüŋ *N. Khal.* хавчиг (Нарийн моднуудыг зүүж хийсэн, амсартаа оосортой, таглаатай, хавчиг модон сав) *Eng.* narrow wooden barrel (with handles on its brim

and lid. It is used to carry water on back of camel or horse) *SD: Kitchen; Container*

kokūr *N. Khal.* хөхүүр (Шимийн архи, айраг мэт шингэн зүйлийг агуулах ширээр хийсэн сав) *Eng.* skin bag (skin bag for containing liquids such as milk vodka and fermented mare's milk) *SD: Container*



bültĕn *N. Morph*: **bült-n** *Khal.* жижиг ширэн хөхүүр *Eng.* smaller skin bag *SD: Container*

könĕg *N. Khal.* хөнөг (Гүүний сүү хийх ширэн сав) *Eng*. skin bag for storing mare's milk *SD: Container*

tulmʌ *N. Khal.* тулам (Малын арьсыг битүүгээр өвчиж, элдэж хийсэн илгэн сав) *Eng.* suede leather bag (that is made from the skin removed in whole) *SD: Container*

tsāgīn tulmʌ *Khal.* цайны тулам (Шахмал цай хийхэд зориулсан илгэн сав) *Eng.* suede bag for containing pressed tea *SD: Container*



dawsʌnā ger *Khal.* давсны илгэн уут *Eng.* suede bag to store salt *SD: Kitchen; Container*



borʲw/börĕw *N. Khal.* борви (Бод малын борвины арьсаар хийсэн ширэн сав) *Eng.* skin bag type (made by the skin around back hip of large cattle: horse, cow or camel) *SD: Container*

boktsʌ *N. Khal.* богц *Eng.* saddle bag *SD: Container*

āgāŋ ger *Khal.* аяганы уут *Eng.* suede bag for bowl *SD: Container*

āg *N. Khal.* аяга (Модон аага, мөнгөн аага гэх мэт) *Eng.* tea bowl (It is made of wood and sometimes coated with silver) *SD: Kitchen items*



džam *N. Khal.* хул (Гүүний айраг уухад зориулсан том модон аяга) *Eng.* type of bowl (Big wooden bowl to drink fermented mare's milk) *SD: Kitchen items*

takšʌ *N. Khal.* тагш (Модон жижиг модон аяга) *Eng.* small wooden bowl *SD: Kitchen items*

dīdz/dīz *N. Khal.* таваг (Амсар нь дэрэвгэр, ялтгар том таваг) *Eng.* large plate (Large plate with an outward curving rim) *SD: Kitchen items*

dīr *N. Khal.* жижиг таваг (Амсар нь дэрэвгэр, ялтгар жижиг таваг) *Eng.* small plate (Small plate with an outward curving rim) *SD: Kitchen items*

bagbăr *N. Khal.* багвар (Арвайн гурил мэтийг хийх таглаатай модон сав) *Eng.* wooden cup (Wooden cup with lid to store flour made of barley etc) *SD: Container*

ɢadăr *Khal.* түмпэн (Төмөрлөгөөр хийсэн гүнзгий биш сав) *Eng.* bucket (Shallow metal basin) *SD: Kitchen items*

xalūɢ *N. Morph*: **xal-ūɢ** *Khal.* халбага (Шингэн ба үйрмэг зүйлийг утгах хэрэгсэл) *Eng.* spoon (Utensil to stir or cup liquid or small-piece substance) *SD: Eating Utensils*

xašʌk/xašʌg *N. Morph*: **xaš-k, xaš-g** *Khal.* халбага (Хоол утган идэх модон ба төмөр хэрэгсэл) *Eng.* table spoon (Table spoon made by wood or metal) *SD: Eating Utensils*

tsatsăl *N. Morph:* **tsats-l** *Khal.* цацал (Хангай дэлхийд сүүний дээж өргөхөд зориулсан, толгойн хэсэгтээ 9 нүхтэй, иштэй мод) *Eng.* type of spoon (Spoon shaped wooden device used for ritual sprinkling) *SD: Kitchen items*



serā̆ *N. Khal.* сэрээ (Хоолыг идэхэд зориулсан 2-4 шүдтэй төмөр ба модон хэрэгсэл) *Eng.* fork (eating utensil consisting of a handle with 2 - 4 prongs on one end. Made by metal or wood) *SD: Eating Utensils*

sawxăd *N. Morph*: **sawx-d** *Khal.* савх (Хоол идэхэд зориулсан яс ба сум модоор хийсэн хос савх. Савхыг хутганы хуйд хийж хадгална) *Eng.* chopsticks (A pair of chopsticks for eating food. Made of bone or wood. It is stored in a knife sheath) *SD: Eating Utensils*

utxʌ *N. Khal.* хутга (Нэг талдаа иртэй, мод ба ясан бариултай огтлох хэрэгсэл) *Eng.* knife (Knife is a cutting tool with a cutting edge and wooden or bone handle) *SD: Kitchen items*

balūdz/bälū̆dz *N. Khal.* балиус *Eng.* big broad knife *SD: Kitchen items*

dzādzūr *N. Morph*: **dzā-dzūr** *Khal.* заазуур (Нэг талдаа иртэй, том өргөн хэрчих хэрэгсэл) *Eng.* chopping knife (Knife with a crescent-shaped blade for chopping) *SD: Kitchen items*

xā̆snā̆ bärū̆l *Khal.* тогооны бариул (Тогоо барихад зориулсан жижиг дөрвөлжин эсгий) *Eng.* pot cloth (Piece of square felt for handling pot) *SD: Kitchen items*

šürgū̆l *N. Morph*: **šürg-ū̆l** *Khal.* шүргүүл (Тогоог арчиж цэвэрлэхэд зориулсан шүргэх хэрэгсэл. Шүргүүлийг адуу ба сарлагийн сүүлээр хийнэ) *Eng.* kitchen cloth (Cloth that is used for wiping and cleaning pots. It is made by the tails of horse or ox) *SD: Kitchen items*

uɢādūr *N. Morph*: **uɢā-dūr** *Khal.* угаагуур (Тогоо угаах өвсөн хэрэгсэл) *Eng.* scrubber, scourer (Brush used for washing pots. Made by hays) *SD: Kitchen items*

šū̆gū̆l *N. Morph:* **šū̆-(g)ū̆l** *Khal.* шүүр (Цайны шаар мэтийг шүүж авахад зориулсан дэрсээр хийсэн шүүр) *Eng.* tea strainer (made by straws used for filtering tea leaves) *SD: Kitchen items*

lagdă/ŋ *N. Khal.* гамбанз (Зуурсан гурил элдэхэд зориулсан хавтгай мод) *Eng.* cutting board (A flat wooden board used to flatten dough on it) *SD: Kitchen items*

ɢulăndzʌ/ɢulūdz *N. Morph*: **ɢul-ndz, ɢul-ūdz** *Khal.* ганжин *Eng.* rolling pin *SD: Kitchen items*

šinăɢ *N. Khal.* шанага (Шингэн юм утгах том халбага *Eng.* dipper (Container that takes up liquid) *SD: Kitchen items;*

